

**АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙГААС БИЧИЛ
УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГУРВАЛСАН ГЭРЭЭ**

2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

№ ИТ-АГ 23/01

Энэхүү гэрээг “Бичил урхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 4.3 дахь заалтын дагуу нэг талаас Увс аймгийн Давст сумын Засаг дарга (Цаашид “Засаг дарга” гэх) Чантуу овогтой Тогтохбаяр, нөгөө талаас тус сумын Шүдэн уул нэртэй газарт ашигт малтмалын 874А тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) “Их Тэмүүлэл” ХХК-ийн захирал Л.Чинбат, гуравдагч талаас “Давс Эрдэнэ” нөхөрлөл (цаашид “Нөхөрлөл” гэх)-ийг төлөөлж ахлагч Гончигсүрэн овогтой Энхбаяр (цаашид хамтад нь “Талууд” гэх) харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн талбайгаас бичил уурхай эрхлэгч этгээд болох “Давс Эрдэнэ” нөхөрлөлд чулуун давс олборлох зориулалтаар талбай ашиглуулахтай холбогдон Засаг дарга, Тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, Нөхөрлөлийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.2. “Давс Эрдэнэ” нөхөрлөл нь тусгай зөвшөөрөл эзэмшигч “Их Тэмүүлэл ХХК”-ийн талбайгаас олборлосон давснаас 300 тонн-оос багагүй давсыг хүлээлгэж өгнө. Хүлээлгэн өгөх давсны 30 хувь нь улаан цагаан өнгөтэй, 1 ширхэг давсны хэмжээ нь 25 см-аас багагүй байна.
- 1.3. Энэхүү гэрээг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүртэл 6 /зургаан/ сарын хугацаатайгаар байгуулав.
- 1.4. Нөхөрлөл нь Давст сумын Засаг даргад олборлолт явуулах өөрсдийн хүсэлтээ гаргасны үндсэн дээр Давст сумын Засаг дарга Ч.Тогтохбаяр бичил уурхайгаар давс олборлох гурвалсан гэрээ байгуулж ажиллах албан хүсэлт ирүүлсний дагуу “Их Тэмүүлэл” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд хүсэлтийг хүлээн авч энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

- 2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүргийг хүлээнэ.
 - 2.1.1. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн дор дурдсан солбилцол бүхий цэгүүдийг холбосон шугамаар хүрээлэгдсэн гектар талбайг нөхөрлөлд ашиглуулах

Цэгийн дугаар	Зүүн уртраг	Хойд өргөрөг
1	92° 35' 9.29"	50° 43' 9.88"



2	92° 35' 17.29 ^{II}	50° 43' 9.88 ^{II}
3	92° 35' 17.29 ^{II}	50° 43' 8.08 ^{II}
4	92° 35' 9.29 ^{II}	50° 43' 8.08 ^{II}
5	92° 35' 9.445 ^{II}	50° 43' 6.075 ^{II}
6	92° 35' 17.318 ^{II}	50° 43' 6.374 ^{II}
7	92° 35' 17.642 ^{II}	50° 43' 4.052 ^{II}
8	92° 35' 9.406 ^{II}	50° 43' 3.524 ^{II}

2.1.2. Нөхөрлөлийг гэрээнд заасан солбилцлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

2.1.3. Нөхөрлөлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

2.1.4. Нөхөрлөлийн чулуун давс олборлох үйл ажиллагаанд аюулгүй байдлын дүрэм мөрдөлтөд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

2.1.5. Чулуун давс олборлох явцад гэнэтийн осол, аваар гарсан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцлага хүлээхгүй ба уг хохирлыг арилгуулахыг шаардах;

2.1.6. Нөхөрлөлийн олборлосон чулуун давсыг ангилах, ялгах цэг, талбайн байршлыг тогтоож өгөх;

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрхтэй. Үүнд:

2.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байхыг нөхөрлөлөөс шаардах;

2.2.2. Нөхөрлөл болон Засаг даргаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.2.3. Нөхөрлөл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах;

2.2.4. Нөхөрлөлийн гишүүдийн татвар, даатгалтай холбоотой асуудлыг хариуцахгүй байх;

2.2.5. Олборлосон чулуун давснаас 300 тонн давсыг Тусгай зөвшөөрөл эзэмшигч "Их Тэмүүлэл" ХХК-д олгохыг шаардах;

2.2.6. Нөхөрлөлийн гэрээт талбайгаас олборлосон чулуун давсны нөөц ашигласны татвар, хураамжтай холбоотой асуудал хариуцахгүй;

2.2.7. Нөхөрлөлийн гишүүд болон удирдах ажилтнуудын анкет болон бусад мэдээллийг Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөхөрлөлөөс гаргуулах эрхтэй.

Гурав. Сумын Засаг даргын эрх, үүрэг

3.1. Сумын Засаг дарга нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 6-р зүйлд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Нөхөрлөл гэрээт талбайд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

АНБ
252
ТЭ
ХХК
УОН

- 3.1.3. Нөхөрлөлийн гишүүдэд “Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийг таниулах, ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд анхан шатны тусламж үзүүлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаар сургалт хийлгэх ажлыг зохион байгуулах;
- 3.1.4. Нөхөрлөлийн гишүүдэд хог хаягдлын цэгийн байршлыг тогтоож өгөх;
- 3.1.5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлд хяналт тавих;
- 3.1.6. Хуулиар олгогдсон эрх үүргийнхээ дагуу Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 3.1.7. Нөхөрлөлийн гишүүдэд бичил уурхай эрхлэгчийн хувьд хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүргийг нь тайлбарлан таниулах;
- 3.1.8. Нөхөн сэргээлт хийлгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайг комисс томилон хүлээж авах, энэ талаарх тайланг аймаг, нийслэлийн засаг дарга, холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
- 3.1.9. Нөхөн сэргээлт хийгээгүй болон ашигт малтмал ашиглах гэрээний үүргээ биелүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдтэй байгуулсан гэрээг цуцлах, түүнтэй дахин гэрээ байгуулахгүй байх.
- 3.2. Засаг дарга дараах эрхтэй. Үүнд:
- 3.2.1. Нөхөрлөл болон Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
- 3.2.2. Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөөгүй тохиолдолд Нөхөрлөлийн чулуун давс олборлох үйл ажиллагааг зогсоож талуудад гэрээг цуцлах тухай санал гаргах;
- 3.2.3. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүргээ хэрэгжүүлэх;
- 3.2.4. Нөхөрлөл нь чулуун давс олборлох явцад гэнэтийн осол аваар гарсан тохиолдолд сумын засаг дарга хариуцлага хүлээхгүй ба уг зөрчлийг арилгахыг шаардах эрхтэй.

Дөрөв. Нөхөрлөлийн эрх, үүрэг

- 4.1. Бичил уурхай эрхлэгч Нөхөрлөл нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.1.1. Гэрээт талбайд чулуун давс олборлох үйл ажиллагаа явуулах;
- 4.1.2. Тусгай зөвшөөрөл эрхлэгчийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;
- 4.1.3. Засаг даргын тогтоосон суурьшлын бүсэд амьдрах, тогтоосон газарт хог хаягдлын цэг байгуулах;
- 4.1.4. Олборлосон чулуун давсыг ангилан ялгах, баяжуулах ажлыг Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тогтоосон талбайд болон төвлөрсөн баяжуулах цехэд гүйцэтгэх;
- 4.1.5. Гэрээт талбайн чулуун давсны нөөцийг бүрэн гүйцэт ашиглах;
- 4.1.6. Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, ослоос урьдчилан сэргийлэх;

АТА
5252

ИХ
МҮҮЛ
ОМП

2525
1918

- 4.1.7. Чулуун давс олборлох үйл ажиллагаанд химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тэсэлж дэлбэлэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглахгүй, үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх;
- 4.1.8. Байгаль орчныг хамгаалж, гол, нуур, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;
- 4.1.9. Нөхөрлөлд гэрээгээр олгосон талбайд зөвхөн нөхөрлөлийн гишүүнийг ажиллуулах;
- 4.1.10. Холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөрлөл нь бичил уурхай эрхлэгч иргэний орлогын албан татвар төлөх;
- 4.1.11. Хууль тогтоомжийг мөрдөх, нийгмийн хэв журмыг сахин биелүүлэх;
- 4.1.12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө батлуулж, нөхөн сэргээлтэд шаардагдах төлбөрийг байршуулж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээнд хавсаргасан байх;
- 4.1.13. Нөхөрлөлийн гишүүдээс бусад этгээдүүд олборлолт хийсэн тохиолдолд нөхөрлөл хариуцлага хүлээх ба гэрээ цуцлагдах хүртэл арга хэмжээ авагдана;
- 4.1.14. Нөхөрлөл олборлосон ашигт малтмалын тайланг бие даан гаргах ба тусгай зөвшөөрөл эзэмшигчид хянуулан баталгаажуулсан байна;
- 4.1.15. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны нөхөн сэргээлт хийхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгаанд идэвхтэй оролцох, өөрсдийн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн ахуй аюулгүй ажиллагааг бүрэн хариуцаж ажиллана;
- 4.1.16. Нөхөрлөл нь үйл ажиллагааны зардал, тайлан татвар хураамжийг өөрсдөө хариуцна;
- 4.1.17. Нөхөрлөл нь нийт гишүүдийн мэдээллийг Засаг дарга болон Тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн өгсөн байна;
- 4.1.18. Хавсралтаар хүлээлгэн өгсөн байдлаас хойш гэрээний хугацаа дууссан болон гэрээг цуцалснаас болж хүлээн авах хүртэл хугацаанд Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хохирол учруулсан тохиолдолд Нөхөрлөл хариуцлага хүлээнэ;
- 4.1.19. Нөхөрлөл нь Давсны уурхайн давс олборлолтын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, хүн хүчээр бүрэн ханган ажиллаж олборлолтын үйл ажиллагааны явцад үүсэх эрсдэлийг болон алдагдлыг бие даан хариуцна.
- 4.2. Нөхөрлөл дараах эрхтэй. Үүнд:
- 4.2.1. Гэрээт талбайд чулуун давс олборлох;
- 4.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх, зохион байгуулалт, технологи сайжруулахтай холбогдсон санал санаачилга гаргах;
- 4.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон засаг даргаас шаардах;
- 4.2.4. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох хүсэлт дахин гаргах.

Тав. Харилцан үүрэг хүлээх

- 5.1. Гэрээний 2.2.3-д заасны дагуу гэрээг цуцлах үндэслэл бий болсон тохиолдолд талуудад гэрээг цуцлах тухай саналаа бичгээр хүргэнэ.
- 5.2. Гэрээний талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.
- 5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсвэл Нөхөрлөлийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, бусад этгээдэд хохирол учирвал уг хохирлыг буруутай тал хариуцна.
- 5.4. Нөхөрлөл нэг л удаа гэрээг зөрчсөн, буруутай үйлдэл гаргасан тохиолдолд Тусгай зөвшөөрөл эзэмшигч нэг талын санаачилгаар шууд гэрээг цуцална.

Зургаа. Давс хүлээлцэх

- 6.1. А тал болон Б талын тохиролцсны дагуу Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүлээлгэн өгч байгаа нийт давсны 30 хувь нь улаан цагаан өнгөтэй байх бөгөөд хүлээлгэн өгч байгаа давсны хэмжээ 300 тонноос багагүй, 1 ширхэг давсны хэмжээ нь 25 см-аас багагүй байна. Үүнд Б тал тухайн жил хэдэн тн давс олборлосон нь үл хамаарна.
- 6.2. Б тал нь олборлосон давсыг гэрээ байгуулсан өдрөөс эхлэн сар бүрийн 30-ны дотор А талд үнэн зөв бодитоор олборлолтын тооцооны дагуу нийлүүлнэ.
- 6.3. Б тал нь А талд нийлүүлэх давсыг гэрээний 6.3-т заасны дагуу Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд байрлах "Гацуурт" ХХК-ийн агуулах хүртэл өөрийн зардлаар тээвэрлэж хүргэх бөгөөд А тал нь давсыг өөрийн баталгаат пүүгээр пүүлж албан ёсоор баримт үйлдэн хүлээн авснаар хүлээлгэж өгсөнд тооцно.

Долоо. Маргаан шийдвэрлэх

- 7.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцох замаар шийднэ.
- 7.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд үүссэн маргааныг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ;

Найм. Бусад зүйл

- 8.1. Энэхүү гэрээ нь 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Талууд гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хойш гэрээ хүчин төгөлдөр болно.
- 8.2. Б тал нь гэрээний 6.2-т заасан хугацаанд давсыг нийлүүлээгүй тохиолдолд гэрээг сунгахгүй буюу цуцлагдсанд тооцно.
- 8.3. Гэрээний хүчинтэй хугацаанд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд гэрээ хүчингүй болно.
- 8.4. Гэрээний хугацаа дуусч нөхөрлөл чулуун давс олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 3.2.10-т заасны дагуу орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
НИЙЦЭЛЭЙН

8.5. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар саналаа аль нэг тал нөгөө талууддаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө талууд ажлын 24 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсвэл хариу өгөөгүй тохиолдолд гэрээ хүчингүй болно;

8.6. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж, Тусгай зөвшөөрөл эзэмшигч 2 хувь, Засаг дарга, Нөхөрлөл тус бүр нэг хувийг хадгална;

8.7. Гэрээний хавсралтууд нь түүний салшгүй хэсэг байна;

Гэрээ зөвшөөрч баталсан:

Батлав:

Увс аймгийн Давст сумын
Засаг дарга

..... Ч.Тогтохбаяр

Хаяг: Увс аймаг,
Давст сум, 2-р баг
Зүүнхөвөө

Утас: 99635213

Батлав:

"Их Тэмүүлэл" ХХК-ийн
Захирал

..... Л.Чинбат

Хаяг: БГД, 20-р хороо
Утас: 99090892

УОН1918 2067884

Батлав:

"Давс Эрдэнэ" Нөхөрлөлийг
төлөөлж Ахлагч

..... Г.Энхбаяр

Хаяг: Увс аймаг,
Давст сум 3-р баг

Утас: 80786188, 88246199

"Их Тэмүүлэл" ХХК-ийг
төлөөлж

Ш.Баянсан

Утас: 99066786

Монголын бичил уурхайн
нэгдсэн холбооны Гүйцэтгэх
захирал

..... Оюунболд

Утас: 99114632

Ерөнхий ня-бо

..... Д.Отгонзаяа

Хуулийн мэргэжилтэн

..... Т.Эрдэнэ